

ЗАХИАЛАГЧ:
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА

Я.АМАРЖАРГАЛ

ГҮЙЦЭТГЭГЧ:
"АЗИМКО" ХХК-НИЙ ЕРӨНХИЙ

ЗАХИРАЛ

Д.ТУУЛ

Халдваргүйжүүлэх үйлчилгээ үзүүлэх гэрээ

2020 оны 12 сар 16 өдөр

№ 486

Улаанбаатар хот

Нэг талаас 9087443 регистрийн дугаартай Эрүүл мэндийн яам (цаашид "Захиалагч" гэх), нөгөө талаас 6494358 тоот регистрийн дугаартай АҮХ-20/22/3797 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээтэй "Азимко" ХХК ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийн үйлчилгээ үзүүлэгч компани (цаашид "Гүйцэтгэгч" гэх) харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Эрүүл мэндийн тухай хуулийн 41, 44 дүгээр зүйл, Эрүүл ахуйн тухай хууль, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/179 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт 11.7, 11.9, тус тушаалын 7 дугаар хавсралт 3.4, 3.5, 4.6.5, 4.7.2 заалтыг үндэслэн хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах, халдварт өвчний голомтыг таслан зогсоохтой холбогдсон харилцааг зохицуулах, олон улсын стандартын түвшинд бүрэн нийцсэн аргачлалын дагуу дараах үйлчилгээг чанартай үзүүлэхэд оршино.

1.1.1. Үйлчилгээний төрөл

Ариутгал, халдваргүйжүүлэлэх үйлчилгээ /Урьдчилан сэргийлэх болон голомтын/

1.1.2. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болж, гэрээний нөхцлийг цаашид хоёр тал баримтлан ажиллана.

Хоёр. Үйлчлэгч байгууллагын үүрэг

2.1. Үйлчилгээний захиалгыг биеэр болон утсаар хүлээн авна.

2.2. Халдваргүйжүүлэх үйлчилгээг олон улсын стандартын шаардлага хангасан халдваргүйжүүлэх бодисоор технологи зааврын дагуу чанартай хийж гүйцэтгэнэ.

2.3. Үйлчлүүлэгч талын мэргэжилтний хамт үйлчилгээ хийлгэх өрөө тасалгааны тоо, талбайн хэмжээг тооцож гаргана.

2.4. Үйлчилгээнд хэрэглэх хор бодисын онцлог, аюулгүй ажиллагааны талаар мэргэжлийн зөвлөлгөө өгч, үйлчилгээ хийх өдөр, цаг, давтамжийг тогтоож, үйлчилгээний төлбөрийг тогтооно.

2.5. Үйлчилгээний чанар зохих стандарт эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй бол үйлчилгээг давтан үнэ төлбөргүй хийж гүйцэтгэнэ.

2.6. Гэрээг үндэслэн ариутгал халдваргүйжүүлэлт хийх зар мэдээг 7 хоногийн өмнө үйлчлүүлэгч байгууллагад мэдэгдэж, урьдчилан бэлтгэлийг бүрэн хангасан байна.

2.7. Өдөр бүрийн халдваргүйжүүлэлт хийсэн тайлан, мэдээг үйлчлүүлэгч байгууллагад хүргүүлнэ.

Гурав. Үйлчлүүлэгч байгууллагын үүрэг

- 3.1. Үйлчилгээний захиалгыг утас болон биеэр очиж өгнө.
- 3.2. Үйлчилгээ хийлгэх газрын өрөө тасалгааны тоо, талбайн хэмжээг танилцуулж, үйлчлүүлэх талбай, үйлчилгээний төрөл, давтамжийг тогтооно.
- 3.3. Үйлчлэгч байгууллагаас өгсөн үйлчилгээний өмнө ба дараа баримтлах зааврыг чанд мөрдөнө.
- 3.4. Үйлчилгээний чанар зохих стандарт эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй бол үйлчилгээг дараагийн үйлчилгээгээ үнэ төлбөргүй хийлгүүлж болно.
- 3.5. Үйлчилгээний төлбөрийг хугацаанд нь барагдуулна.

Дөрөв. Гэрээний хугацаа

- 4.1. 2020 оны 11 дугаар сарын 27-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдөр 13 хоногийн хугацаатай байгуулав.
- 4.2. Гэрээний хугацаа дууссан боловч талууд гэрээг дуусгавар болгох тухай нөгөө талдаа албан ёсоор мэдэгдээгүй бол гэрээг цаашид ижил хугацаа, нөхцөлтэйгээр сунгагдсанд тооцно.
- 4.3. Талууд хүндэтгэн үзэх шалтгаанаар гэрээг цуцлах, өөрчлөх бол 1 сарын өмнө албан ёсоор мэдэгдэх ба талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

Тав. Төлбөр тооцоо

5.1. Шинжилгээ хийх 20 түр цэгийн эхний халдваргүйжүүлэх ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр тухайн давхарын нийт талбай /бүх талбай/-д хийх, цаашид 2020 оны 12 сарын 01-ний өдрөөс 12 сарын 09-ний өдрийг дуустал Баянгол дүүрэгт байрлах 4 шинжилгээ хийх түр цэгийн үйл ажиллагааг дуустал өдөр бүр байнгын халдваргүйжүүлэх ажлыг чанартай хийж гүйцэтгэнэ. 1 мкв талбайн үнэлгээ 300 төгрөг байна.

5.2 Захиалагч байгууллага нь Кононавируст халдвар (COVID-19)-ын шинжилгээ хийх түр цэгт халдваргүйжүүлэх ажил хийсэн төлбөр болох 18,006,900 (арван найман сая зургаан мянга есөн зуу) төгрөгийг үйлчилгээг авсны дараа 3 хоногийн дотор бэлэн бусаар байгууллагын РД:6494358 Хаан банкны 5075705543 дугаартай дансанд төлбөрийг хийнэ.

5.3. Шинжилгээ авах цэгүүд

Дүүрэг	Цэгүүд	Ахлах	Талбайн хэмжээ	Давтамж	Нийт талбайн хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
Баянгол	Эрдмийн Өргөө	Ж.Мягмарсүрэн	600	10	6000	300	1,800,000
	Оюуны Ундраа	Ж.Мягмарсүрэн	1200	10	12000	300	3,600,000
	38-р сургууль	Ж.Мягмарсүрэн	1450	10	14500	300	4,350,000
	141-р сургууль	Ж.Мягмарсүрэн	780	10	7800	300	2,340,000
Баянзүрх	21-р сургууль	С.Сүрэнхорлоо	1440	1	1440	300	432,000
	44-р сургууль	С.Сүрэнхорлоо	2140	1	2140	300	642,000
	87-р сургууль	С.Сүрэнхорлоо	1346	1	1346	300	403,800

Энгийнхоа хан	102-р сургууль	С.Сүрэнхорлоо	587	1	587	300	176,100
	62-р сургууль	Ж.Мягмарсүрэн	1100	1	1100	300	330,000
	67-р сургууль	Ж.Мягмарсүрэн	1400	1	1400	300	420,000
	106-р сургууль	Ж.Мягмарсүрэн	1300	1	1300	300	390,000
	Өнөр цогцолбор	Ж.Мягмарсүрэн	1200	1	1200	300	360,000
ан-Уул	15-р сургууль	С.Сүрэнхорлоо	1160	1	1160	300	348,000
	32-р сургууль	С.Сүрэнхорлоо	1640	1	1640	300	492,000
	41-р сургууль	С.Сүрэнхорлоо	1310	1	1310	300	393,000
	114-р сургууль	С.Сүрэнхорлоо	1430	1	1430	300	429,000
үхбаата	4-р сургууль	С.Сүрэнхорлоо	1100	1	1100	300	330,000
	31-р сургууль	С.Сүрэнхорлоо	1360	1	1360	300	408,000
ингэлтэй	37-р сургууль	С.Сүрэнхорлоо	590	1	590	300	177,000
	39-р сургууль	С.Сүрэнхорлоо	620	1	620	300	186,000
Нийт					60023		18,006,900

Зургаа. Бусад

6.1. Хоёр тал гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар гэрээ хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээг заавал 4% үйлдэнэ.


6.2. Ажил үйлчилгээний явцад хяналт тавих ажилтныг 2 талаас гаргаж ажиллуулна.

6.3. Үйлчилгээний чанартай холбогдон гарсан санал гомдлыг 2 тал хэлэлцэж, шалтгааныг тогтоон хамтран шийдвэрлэнэ. Асуудлыг шийдвэрлэх боломжгүй бол хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

Нийгмийн эрүүл мэндийн газрын
дарга

 Т.Энхзаяа

Хянасан: Төрийн захиргааны удирдлагын
газар, Хуулийн хэлтсийн мэргэжилтэн


 Д.Мөнхцэцэг

Боловсруулсан:

мэргэжилтэн  Г.Гэрэлмаа

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Менежер ажилтай

 М.Мөнгөнбагана

Хаяг: УБ хот БЗД 16-р хороо

АОС 36А

Утас: 88048733, 88008782,

МОНГОЛ УЛС
MONGOLIA



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
SPECIAL PERMIT TO CONDUCT PROFESSIONAL
ACTIVITIES IN MEDICAL FIELD

06475

ГЭРЧИЛГЭЭ CERTIFICATE

ГОСОН 2020 он 6 сар 9 өдөр
(year) (month) (date)

Дугаар № АҮХ-20/22/3797
(number)

"Азимко" ХХК

Иргүүллагын нэр
(name of organization) Дагийсүрэн Туул

Ажиллагааны чиглэл Ахуйн хортон шавьж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийн
(type /field/ of activity) үйлчилгээ

Ажиллагаа явуулах нутаг дэвсгэр Баянзүрх дүүрэг
(permitted territory)

Иргүүллагын албан ёсны хаяг 16-р хороо 16-р хороолол С.Данзангийн гудамж 23 тоот
(address of organization)

Сын бүртгэлийн гэрчилгээний дугаар 9011812800 6494358
(state registration number)

Харьяагчдын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар
(number of certificate of foreign incorporated company)

Гэрчилгээ 2023 он 6 сар 9 өдөр хүртэл хүчинтэй.
(certificate) (year) (month) (date) (valid)

КОМИССЫН ДАРГА
(chairman of the Commission)

Гарын үсэг
(Signature)

Ш.АНХМАА
(chairman's name)